



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /97/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.08.25 № 85
танай _____-ны № _____-т

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА
А.НАРАНБОЛД ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>125 613 147,00</u>	<u>125 793 643,00</u>
33	АВЛАГА	19 994 956,00	19 994 956,00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	19 994 956,00	19 994 956,00
35	БАРАА МАТЕРИАЛ	105 618 191,00	103 798 687,00
351	Түүхий эд материал	49 351 208,00	63 003 544,00
35110	Тусгай зориулалттай материал	44 054 908,00	61 172 844,00
35130	Эм боох материал	5 296 300,00	3 830 700,00
354	Хангамжийн материал	56 266 983,00	40 795 143,00
35410	Бичиг хэргийн материал	50 000,00	50 000,00
35420	Аж ахуйн материал	44 329 983,00	37 585 043,00
35440	Түлш, шатах тослох материал	700 000,00	887 600,00
35460	Хүнсний материал	8 540 000,00	1 875 500,00
35470	Бусад хангамжийн материал	2 647 000,00	397 000,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5 118 733 347,80</u>	<u>5 034 677 932,78</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5 118 733 347,80	5 032 677 932,78
392	Биет хөрөнгө	4 861 247 547,80	4 775 192 132,78
39201	Барилга, байгууламж, орон сууц	4 961 132 075,00	4 628 080 762,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(206 898 894,18)	(298 952 117,16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21 500 000,00	21 500 000,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(6 942 708,23)	(9 630 208,19)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	161 854 175,52	290 683 275,52
39206	Хуримтлагдсан элэгдэл	(122 210 657,19)	(145 359 183,79)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	119 279 468,00	142 836 418,00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(86 324 091,11)	(102 614 912,35)
39209	Зам, гүүрийн байгууламж	24 505 693,00	24 505 693,00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(6 803 181,00)	(10 177 088,88)
39214	Бусад үндсэн хөрөнгө	27 278 000,00	261 498 000,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(25 122 332,01)	(27 178 505,37)
393	Биет бус хөрөнгө	257 485 800,00	259 485 800,00
39301	Програм хангамж	350 000,00	2 350 000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(350 000,00)	(350 000,00)
39303	Бусад биет бус хөрөнгө	257 485 800,00	257 485 800,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>5 244 346 494,80</u>	<u>5 160 471 575,78</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5 244 346 494,80</u>	<u>5 160 471 575,78</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5 244 346 494,80	5 158 471 575,78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1 733 807 593,32	1 733 807 593,32
512	Хуримтлагдсан үр дүн	1 815 740 014,39	1 731 865 095,37
51210	Өмнөх үеийн үр дүн	(135 788 932,15)	1 815 740 014,39
51220	Тайлант үеийн үр дүн	1 951 528 946,54	(83 874 919,02)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1 694 798 887,09	1 694 798 887,09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>5 244 346 494,80</u>	<u>5 160 471 575,78</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2 610 741 070,00	1 203 269 520,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2 036 104 593,00	389 741 950,00
120	Нийтлэг татварын бус орлого	2 036 104 593,00	389 741 950,00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	2 034 793 01200	380 213 650,00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	1 311 581,00	9 528 300,00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	574 636 477,00	813 527 570,00
1310	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	443 112 600,00	412 582 900,00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	443 112 600,00	412 582 900,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	108 301 077,00	377 721 870,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	106 361 077,00	366 759 870,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1 940 000,00	10 962 000,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	23 222 800,00	23 222 800,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23 222 800,00	23 222 800,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	654 263 847,46	956 016 863,36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	654 263 847,46	956 016 863,36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	603 068 537,20	853 716 756,47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252 725 306,00	311 665 450,30
210101	Үндсэн цалин	188 456 552,53	229 668 656,21
210102	Нэмэгдэл	54 669 955,18	64 622 472,78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9 598 798,29	17 374 321,31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34 763 755,00	43 321 865,54
210201	Тэтгэврийн даатгал	25 692 955,00	30 376 356,36
210202	Тэтгэмжийн даатгал	2 267 700,00	3 120 590,10
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 814 200,00	2 643 608,15
210204	Ажилгүйдлийн даатгал	453 500,00	649 438,35
210205	Эрүүл мэндийн даатгал	4 535 400,00	6 531 872,58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28 652 178,74	34 980 646,27
210301	Гэрэл, цахилгаан	5 696 164,70	5 812 033,58
210302	Түлш, халаалт	12 403 529,44	17 384 831,27
210303	Цэвэр, бохир ус	3 397 835,60	4 796 277,42
210304	Байрны түрээс	7 154 649,00	6 987 504,00
2104	Хангамж, бараа материалын зардал	12 213 000,00	17 486 357,80
210401	Бичиг хэрэг	2 913 000,00	5 641 520,00
210402	Тээвэр, шатахуун	2 800 000,00	3 125 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 800 000,00	2 655 200,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2 000 000,00	3 151 107,80
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2 700 000,00	2 913 530,00

2105	Нормативт зардал	1 700 000,00	13 188 642,20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200 000,00	3 399 000,20
210502	Хоол, хүнс	1 500 000,00	9 789 642,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2 000 000,00	25 948 000,00
210604	Урсгал засвар	2 000 000,00	25 948 000,00
2107	Томилолт, зочны зардал	1 500 000,00	208 600,00
210702	Дотоод албан томилолт	1 500 000,00	208 600,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	157 140 477,00	249 989 701,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	153 636 177,00	244 147 591,00
210803	Даатгалын үйлчилгээ	165 000,00	165 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100 000,00	100 000,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88 000,00	74 510,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1 500 000,00	2 700 000,00
210807	Газрын төлбөр	1 401 300,00	2 802 600,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	250 000,00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112 373 820,46	156 927 493,36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2 420 000,00	7 830 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6 984 200,00	5 324 200,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	102 969 620,46	143 773 293,36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51 195 310,26	102 300 106,89
2132	Бусад урсгал шилжүүлэг	28 105 700,00	2 407 400,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2 000 000,00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25 055 700,00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1 050 000,00	2 407 400,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		3 132 000,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		3 132 000,00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7 882 845,26	67 609 153,89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2 913 150,47	7 033 694,41
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4 969 694,79	60 575 459,48
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	15 206 765,00	29 151 553,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15 206 765,00	29 151 553,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1 956 477 222,54	249 252 656,64
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4 948 276,00	333 127 575,66
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	328 888 171,66
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	4 948 276,00	4 239 404,00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1 951 528 946,54	(83 874 919,02)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н оруулсан капитал
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1 733 807 593,32	1 694 798 887,09	1 815 740 014,39	5 244 346 494,80

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
Тайлант үеийн үр дүн			(83 874 919,02)	(83 874 919,02)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 733 807 593,32	1 694 798 887,09	1 731 865 095,37	5 160 471 575,78

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	586 594 267,00	819 493 411,54
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	443 112 600,00	412 582 900,00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	443 112 600,00	412 582 900,00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	443 112 600,00	412 582 900,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	143 481 667,00	406 910 511,54
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	115 631 077,00	377 721 870,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	107 801 077,00	366 759 870,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7 830 000,00	10 962 000,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	23 222 800,00	23 222 800,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23 222 800,00	23 222 800,00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4 627 790,00	5 965 841,54
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4 627 790,00	5 965 841,54
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	584 944 567,00	811 101 011,54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	584 944 567,00	811 101 011,54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	521 791 466,74	697 005 063,11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252 725 306,00	311 665 450,30
210101	Үндсэн цалин	188 456 552,53	229 668 656,21
210102	Нэмэгдэл	54 669 955,18	64 622 472,78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9 598 798,29	17 374 321,31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34 763 755,00	43 321 865,54
210201	Тэтгэврийн даатгал	25 692 955,00	30 376 356,36
210202	Тэтгэмжийн даатгал	2 267 700,00	3 120 590,10
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 814 200,00	2 643 608,15
210204	Ажилгүйдлийн даатгал	453 500,00	649 438,35
210205	Эрүүл мэндийн даатгал	4 535 400,00	6 531 872,58

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28 652 178,74	34 980 646,27
210301	Гэрэл, цахилгаан	5 696 164,70	5 812 033,58
210302	Түлш, халаалт	12 403 529,44	17 384 831,27
210303	Цэвэр, бохир ус	3 397 835,60	4 796 277,42
210304	Байрны түрээс	7 154 649,00	6 987 504,00
2104	Хангамж, бараа материалын зардал	12 213 000,00	16 457 600,00
210401	Бичиг хэрэг	2 913 000,00	2 925 000,00
210402	Тээвэр, шатахуун	2 800 000,00	3 125 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 800 000,00	2 655 200,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2 000 000,00	4 185 200,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2 700 000,00	3 567 200,00
2105	Нормативт зардал	1 700 000,00	6 440 000,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200 000,00	-
210502	Хоол, хүнс	1 500 000,00	5 000 000,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1 440 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5 380 300,00	28 617 000,00
210602	Тавилга	350 300,00	367 000,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3 030 000,00	
210604	Урсгал засвар	2 000 000,00	28 250 000,00
2107	Томилолт, зочны зардал	1 500 000,00	208 600,00
210702	Дотоод албан томилолт	1 500 000,00	208 600,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	175 452 727,00	247 989 701,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	171 948 427,00	242 147 591,00
210803	Даатгалын үйлчилгээ	165 000,00	165 000,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100 000,00	100 000,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88 000,00	74 510,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1 500 000,00	2 700 000,00
210807	Газрын төлбөр	1 401 300,00	2 802 600,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	250 000,00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9 404 200,00	5 324 200,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2 420 000,00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6 984 200,00	5 324 200,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63 153 100,26	116 095 948,43
2132	Бусад урсгал шилжүүлэг	32 733 490,00	8 373 241,54
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4 627 790,00	5 965 841,54
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25 055 700,00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3 050 000,00	2 407 400,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15 206 765,00	29 151 553,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15 206 765,00	29 151 553,00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15 212 845,26	78 571 153,89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15 212 845,26	78 571 153,89

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1 649 700,00	6 392 400,00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1 649 700,00	8 392 400,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1 649 700,00	8 392 400,00
2200	Дотоод эх үүсвэрээр	1 649 700,00	8 392 400,00
222001	Тоног төхөөрөмж	1 649 700,00	8 392 400,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1 649 700,00)	(8 392 400,00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	435 805 600,00	438 775 387,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	435 805 600,00	438 215 487,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	435 805 600,00	396 653 152,59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	226 770 600,00	209 047 948,62
210101	Үндсэн цалин	164 138 400,00	146 574 657,20
210102	Нэмэгдэл	54 632 200,00	51 689 969,76
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8 000 000,00	10 783 321,66
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30 614 000,00	29 725 676,38
210201	Тэтгэврийн даатгал	21 543 200,00	20 926 227,76
210202	Тэтгэмжийн даатгал	2 267 700,00	2 071 317,60
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 814 200,00	1 804 150,30
210204	Ажилгүйдлийн даатгал	453 500,00	447 634,62
210205	Эрүүл мэндийн даатгал	4 535 400,00	4 476 346,10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22 222 800,00	15 189 105,59
210301	Гэрэл, цахилгаан	6 081 400,00	3 361 255,89
210302	Түлш, халаалт	12 056 400,00	8 644 902,08
210303	Цэвэр, бохир ус	4 085 000,00	3 182 947,62
2104	Хангамж, бараа материалын зардал	3 500 400,00	3 500 400,00
210401	Бичиг хэрэг	1 125 000,00	1 125 000,00
210402	Тээвэр, шатахуун	1 125 000,00	1 125 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	625 200,00	625 200,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	625 200,00	625 200,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1 000 000,00	1 000 000,00
210604	Урсгал засвар	1 000 000,00	1 000 000,00
2107	Томилолт, зочны зардал	208 600,00	208 600,00
210702	Дотоод албан томилолт	208 600,00	208 600,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	146 165 100,00	132 657 222,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	139 062 100,00	128 015 112,00
210803	Даатгалын үйлчилгээ	165 000,00	165 000,00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	100 000,00	100 000,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88 000,00	74 510,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1 500 000,00	1 500 000,00
210807	Газрын төлбөр	5 000 000,00	2 802 600,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5 324 100,00	5 324 200,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5 324 100,00	5 324 200,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	41 562 334,41
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	5 377 087,00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	2 969 687,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2 407 400,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		29 151 553,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		29 151 553,00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох		7 033 694,41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		7 033 694,41
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	559 900,00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	559 900,00
222001	Тоног төхөөрөмж	-	559 900,00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	435 805 700,00	438 775 387,00
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23 222 800,00	23 222 800,00
132001	Орон нутгийн төсвөөс	23 222 800,00	23 222 800,00
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	2 969 687,00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	2 969 687,00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1,00	1,00
610001	Төсвийн байгууллага	1,00	1,00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24,00	24,00
620001	Удирдах ажилтан	1,00	1,00
620002	Гүйцэтгэх ажилтан	10,00	10,00
620003	Үйлчлэх ажилтан	10,00	10,00
620004	Гэрээт ажилтан	3,00	3,00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	108 301 077,00	377 721 870,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	108 301 077,00	369 889 370,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26 028 432 976,21	306 184 410,52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25 954 706 000,00	102 617 501,68
210101	Үндсэн цалин	25 954 706 000,00	83 093 999,01
210102	Нэмэгдэл		12 932 503,02
210103	Унаа хоолны хөнгөлөлт		6 590 999,65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4 149 655,00	13 596 189,16
210201	Тэтгэврийн даатгал	4 149 655,00	9 450 128,60
210202	Тэтгэмжийн даатгал		1 049 272,50
210203	ҮОМШӨ-ний даатгал		839 457,85

210204	Ажилгүйдлийн даатгал		201 803,73
210205	Эрүүл мэндийн даатгал		2 055 526,48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10 342 529,21	19 791 540,68
210301	Гэрэл, цахилгаан	393 913,17	2 450 777,69
210302	Түлш, халаалт	2 569 375,44	8 739 929,19
210303	Цэвэр, бохир ус	224 591,60	1 613 329,80
210304	Байрны түрээс	7 154 649,00	6 987 504,00
2104	Хангамж, бараа материалын зардал	5 913 000,00	12 957 200,00
210401	Бичиг хэрэг	413 000,00	1 800 000,00
210402	Тээвэр, шатахуун	1 000 000,00	2 000 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	800 000,00	2 030 000,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1 000 000,00	3 560 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2 700 000,00	3 567 200,00
2105	Нормативт зардал	1 700 000,00	6 440 000,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	200 000,00	
210502	Хоол, хүнс	1 500 000,00	5 000 000,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		1 440 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3 380 300,00	27 617 000,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	350 300,00	
210602	Тавилга		367 000,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3 030 000,00	
210604	Урсгал засвар		27 250 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44 161 492,00	115 332 479,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44 161 492,00	114 132 479,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1 200 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4 080 000,00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2 420 000,00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1 660 000,00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2 000 000,00	71 537 459,48
2132	Бусад урсгал шилжүүлэг	2 000 000,00	7 830 000,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2 000 000,00	
2133	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		63 707 459,48
213301	Төвлөрүүлэх шилжүүлэг		63 707 459,48
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1 649 000,00	7 832 500,00
2200	Дотоод эх үүсвэрээр	1 649 000,00	7 832 500,00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1 649 000,00	7 832 500,00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	108 301 077,00	377 721 870,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	108 301 077,00	377 721 870,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	106 361 077,00	366 759 870,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1 940 000,00	10 962 000,00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/40 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь Хүүхэд гэр залуучуудын эрх хамгаалал, хөгжлийн чиглэлээр явуулах бодлогыг тодорхойлох хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тэдний нийгмийн эрх ашгийг хамгаалах зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад даргын тушаалаар байгуулагдсан дотоод хяналтын зөвлөл ажилладаг байна. Дотоод хяналтын зөвлөл нь тухайн онд хийх ажлын төлөвлөгөө гарган төлөвлөгөөний дагуу холбогдох ажлуудыг зохион байгуулж, үр дүнг тайлагнан ажилладаг байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 436,000.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,360.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,052.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 85,874.9 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Бараа материал	105,618.2	103,798.7	(1,819.2)
Үндсэн хөрөнгө	5,118,733.3	5,034,677.9	(84,055.4)
Нийт хөрөнгө	5,244,346.5	5,158,471.6	(85,874.9)
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,244,346.5	5,158,471.6	(85,874.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,244,346.5	5,158,471.6	(85,874.9)

Бараа материалын данс 103,798.7 мянган төгрөг болж өмнөх оноос 1,819.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 131,441.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, 133,260.7 мянган төгрөгөөр буурч, аудитаар 16,222.9 мянган төгрөгийн аж ахуйн материалыг тусгай зориулалтын бараа материал руу шилжүүлж, 2,000.0 мянган төгрөгийн программыг аж ахуйн материалд бүртгэлтэй байсныг залруулж, биет бус хөрөнгөд бүртгэж залруулсан.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 84,055.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд Орхон аймгийн Засаг даргын А/443 дугаар захирамжийн дагуу Залуучуудын ордны гадна тохижолтын бусад үндсэн хөрөнгүүдийг шилжүүлэн авч, Залуучуудын ордны барилгын гадна дулаан, халуун усны шугам сүлжээг “Эрдэнэт ус ДТС” ОНӨХК-д шилжүүлэн мөн тайлант хугацааны элэгдлээр буурсан үзүүлэлттэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,158,471.6 мянган төгрөг болж өмнөх оноос 85,874.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Орхон аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 440,124.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 440,124.0 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж, төсвийг 412,582.9 мянган төгрөгөөр батлуулан авсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд гэр бүл болон хүүхэд хамгаалалын арга хэмжээг хэрэгжүүлэхээр 412,582.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 23,222.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, нэмэлт санхүүжилтаас 377,721.9 мянган төгрөг буюу нийт 1,203,269.5 мянган төгрөгөөр санхүүжсан. Уг санхүүжилтаас урсгал үйл ажиллагаандаа 853,716.7 мянган төгрөгийг зарцуулж, 29,151.6 мянган төгрөгийг улсын төсөвт, 78,571.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 853,716.7 мянган төгрөг буюу 99.7 хувьтай зарцуулсан байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 7,033.7 мянган төгрөг буюу 68.4 хувьтай зарцуулсан боловч бусад зардлуудыг хэтрэлттэй зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн төсвөөс 366,759.9 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого болох 10,962.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1-т “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлох” гэсэн заалтын дагуу нийгмийн даатгалын тайланг үнэн зөв тооцож тайлагнах.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Орхон аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь 2021 онд нийт 150 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 1,245,895.6 мянган төгрөгийн 143 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж, батлагдсан орон тоо, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэмнэлт хэтрэлтийн шалтгаантай тайлбарын 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон нийт 6,788.7 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс 2,829.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 719.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 3,240.6 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	2	2,829.1	2	2,829.1			
Албан шаардлага	1	719.0	1	719.0			
Зөвлөмж	2	3240.6	2	3240.6			
Нийт дүн	5	6,788.7	5	6,788.7			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орхон аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь цалинг тооцохдоо татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг хууль тогтоомж, заавар журмын дагуу зөв бодож татвар нийгмийн даатгалын тайлангуудтай тулган баталгаажуулахад анхаарах нь зүйтэй гэж үзэж байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 23,161.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 18,500.4 мянган төгрөгийн 2 алдаа зөрчлийг залруулж, 2,423.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 албан шаардлага, 2,237.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж хүргүүлсэн.

4.1 Залруулсан алдаа

1. Бараа материалын аж ахуйн дансанд 16,312.8 мянган төгрөгийн тусгай зориулалтын материалыг тусгаж залруулсан, мөн бараа материал дансанд 2 000.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө бүртгэлтэй байсныг залруулж тайлагнуулсан.

2. Шатахууны гэрээний дагуу олгодог 187.6 мянган төгрөгийн шатахууны урамшууллыг орлогод авч бүртгэлд тусгаагүй байсныг залруулж үнэ төлбөргүй авсан орлогод бүртгэж залруулсан.

4.2 Албан шаардлага

1. Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуудал

Төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах Засгийн газрын 43-р тогтоолоор батлагдсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.6-д "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй тайлангийн хугацаанд 300.0 мянган төгрөгийн шагнал урамшуулал олгосон байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Шилэн дансанд байгууллагын батлагдсан орон тоо, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэмнэлт хэтрэлтийн шалтгаантай тайлбарын нийт 6 мэдээлэл хоцроож мэдээлсэн тул албан шаардлага хүргүүлэв.

3. Нийгмийн даатгалын тайлагналтай холбоотой асуудал

Хүүхэд асрагч болон сургалт өгдөг багш, хуульч нарын ажлын хөлснөөс 890.1 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл тооцоогүй байна. Мөн 1-6-р сард Залуучууд хөгжлийн төвийн ажиллагсдын нийгмийн даатгалын шимтгэлийг 1 хувиар дутуу тооцоолон 118.5 мянган төгрөгийг дутуу суутгасан, 1-р сард групптэй Хишигбаярын НДШ-ийн хувийг буруу тооцоолон 11.6 мянган төгрөгийг илүү суутган байгаа нь "Нийгмийн даатгалын тухай" хуулийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлэв.

4. Анхан шатны баримтын иж бүрдэлтэй холбоотой асуудал

Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу и-баримтгүй 676.9 мянган төгрөгийн гүйлгээ, 216.0 мянган төгрөгийн томилолт, 210.0 мянган төгрөгийн хоолны мөнгө хувь хүний сугалаатай баримт хавсаргасан байна. Хүүхэд хамгаалалын зардлаар хийж гүйцэтгэж байгаа ажлуудын ажлын баримт дутуу хангалтгүй байгаа нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д "...дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн тул албан шаардлага хүргүүлэв.

4.3 Акт

Тайлант хугацааны тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчилд төлбөрийн акт хүргүүлээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хувь хүний орлогын татварын тухай хууль, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Хөдөлмөрийн чадвар алдалттай ажиллагсдын цалингаас 848.7 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутган тооцсон байгаа нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25.3-д "Суутган төлөгч нь хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлогод албан татвар ногдуулахад холбогдох нотлох баримтыг үндэслэн энэ хуулийн 22.1.2-т заасан чөлөөлөлтийг хасаж тооцно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөрийн чадвар алдалттай ажиллагсдын цалинг тооцоолохдоо холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв тооцож тайлагнах.

2. Хөдөлмөрийн тухай хууль, ээлжийн амралтын тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Хөдөлмөрийн чадвар алдалттай ажилтны амралтыг бодохдоо хөдөлмөрийн чадвар алдалттай хүнд нэмж олгох 5 хоногийг нэмж амруулаагүй 5 хоногийн амралтын мөнгийг ажлын өдрөөр тооцож 92.7 мянган төгрөг дутуу бодож олгосон байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99.4-т "Хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадвар алдалттай ажилтан болон 18 насанд хүрээгүй ажилтны ээлжийн үндсэн амралтын хугацаа ажлын 20 өдөр байна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөрийн чадвар алдалттай ажилчдын амралтын хоногийг нэмж биеэр амрааж амралтын мөнгийг тооцож олгох.

3. Цалин хөлсний тайлагналтай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Цалингийн дансанд сорил гүйцэтгэхэд цалингийн хүснэгтээрх цалин, нийгмийн даатгалын тайлангийн цалин хоорондоо 1,296.0 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнагдсан байгаа нь "Нийгмийн даатгалын тухай" хуулийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Цалинг тооцохдоо татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг хууль тогтоомж, заавар журмын дагуу зөв бодож татвар нийгмийн даатгалын тайлангуудтай тулган баталгаажуулж байх.

4. Зардлын тайлагналтай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Байгууллагын автомашины километрийн спидометр ажилладаггүй явсан км тодорхойгүй тооцоо бодолт, шатахууны тайлан хангалтгүй байна. 3,125.0 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтад хяналт тавих боломжгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Шатахууны тооцоог бодитой үнэн зөв хийж, тайланг холбогдох заавар журмын дагуу бүрэн хийж хэвших.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн нэгтгэл		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар	10	23,161.0	2	18,500.4			4	2,423.1	4	2,237.5
Нийт		10	23,161.0	2	18,500.4			4	2,423.1	4	2,237.5

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН:

“БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:

Б.Пүрэвсүрэн

Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ:

Д.Мягмарсүрэн

Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Б.Эрдэнэ

Б.ЭРДЭНЭ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ц.Нармандах

Ц.НАРМАНДАХ

6117143090
ΦΑΑ0073 9042806